

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар сарын ...-ны
өдөр Улаанбаатар хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ

/шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, нэн ховор, ховор амьтан, ургамал бүхий газар, соёлын өвийн болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах, орчны бүс тогтоох, тэдгээрийн менежментийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж

2.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Газрын тухай хууль[2], Байгаль орчныг хамгаалах тухай хууль[3], Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль[4], Соёлын өвийг хамгаалах тухай хууль[5], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

3.1.1. “тусгай хамгаалалттай газар нутаг” гэж байгалийн унаган төрхийг хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, нэн ховор, ховор амьтан, ургамал, байгалийн болон соёлын өв бүхий газар нутгийг хамгаалах, нөхөн сэргээх, экосистемийн үйлчилгээ, үнэ цэнэ, иж бүрдлийг алдагдуулахгүй байх зорилгоор энэ хуульд заасны дагуу улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан газар нутгийг;

3.1.2. “тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ” гэж улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын бүртгэл, менежментийн нэгдсэн тогтолцоог;

3.1.3. “тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” гэж тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалахтай холбоотой байгаль, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг судлах, төлөвлөх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх, үр дүнг тооцох үйл явцыг талуудын оролцоотойгоор, үр ашигтай, цогц байдлаар удирдан зохион байгуулахыг;

3.1.4. “тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн тусгай хамгаалалттай газрын менежментийн зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон баримт бичгийг;

3.1.5. "тусгай хамгаалалттай газар нутгийн бизнес төлөвлөгөө" гэж тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, зардал, санхүүжилтийн эх үүсвэр, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

3.1.6. "экосистем" гэж өөр хоорондоо идэш тэжээлийн хэлхээгээр холбогдсон бүх амьд бие, тэдгээрийн бодисын солилцоо, энергийн хувиралд зайлшгүй хэрэгтэй орчин, амьгүй бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл тогтолцоог;

3.1.7. "экосистемийн үйлчилгээ" гэж тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль, байгалийн нөөц, соёлын өв, экосистемээс улс орон болон хүнд үзүүлж буй эрүүл мэнд, сэтгэл ханамж, танин мэдэхүйн болон үйлдвэрлэл, үйлчилгээ, эдийн засгийн үр ашиг, үр нөлөөг;

3.1.8. "тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүс" гэж тухайн тусгай хамгаалалттай газрын хилийн цэсийн дотор орших байгалийн хэв шинжийг төлөөлөх онцлог, нэн ховор, ховор амьтан, ургамал, соёлын өвийг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон, хоорондоо хамгаалалтын ялгаа бүхий дэглэмтэй газрыг;

3.1.9. "тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын дэглэм" гэж тусгай хамгаалалттай газарт байгаль хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглахад тавигдах нийтлэг шаардлага, хэм хэмжээг;

3.1.10. "тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын горим" гэж тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын дэглэмийг тухайн тусгай хамгаалалттай газрын газарзүйн байршил, байгаль, экосистем, нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлог, орон нутгийн уламжлалт соёл, зан заншлыг харгалзан хэрэгжүүлэх хэм хэмжээг;

3.1.11. "хамгаалалтын захиргаа" гэж улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, эсхүл энэ хуульд заасан эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр менежментийг хариуцан хэрэгжүүлж буй байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг;

3.1.12. "тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс" гэж тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлж байгаа болон үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор ногоон хөгжлийн загвар экологийн цэвэр бүс нутаг болгон хөгжүүлэх зарчимд нийцүүлэн энэ хуульд заасан шалгуурыг харгалзан тогтоосон тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хил залгаа газар нутгийг;

3.1.13. "тусгай хамгаалалттай газрын хамтын менежмент" гэж тусгай хамгаалалттай газар нутгийн болон түүний орчны бүсийн менежментийг нутгийн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдтэй тодорхой нөхцөл, болзол бүхий гэрээний үндсэн дээр харилцан ашигтай хамтран хэрэгжүүлэхийг;

3.1.14. "байгалийн нөөцийн зохистой ашиглалт" гэж байгалийн нөөцийг байгалийн жамаар өсөх, нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр судалгаа, төлөвлөгөөнд үндэслэн ашиглахыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН АНГИЛАЛ

4 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал

4.1. Тусгай хамгаалалттай газар нутаг нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгаас бүрдэнэ.

4.2. Тусгай хамгаалалттай газар нутаг нь байгалийн нөөц, биологийн төрөл зүйл, байгаль, соёлын өвийг хамгаалах, зохистой ашиглах зорилго, шаардлагыг харгалзан тогтоосон дараах ангилалтай байна:

4.2.1. дархан цаазат газар;

4.2.2. байгалийн цогцолборт газар;

4.2.3. байгалийн нөөц газар;

4.2.4. дурсгалт газар.

4.3. Орон нутгийн тусгай хамгаалалтад энэ хуулийн 4.2.3, 4.2.4-т заасан ангиллаар авна.

5 дугаар зүйл. Дархан цаазат газар

5.1. Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах онгон, унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ.

6 дугаар зүйл. Дархан цаазат газрын ангиллаар тусгай хамгаалалтад авах шалгуур үзүүлэлт

6.1. Газар нутгийг дархан цаазат газрын ангиллаар тусгай хамгаалалтад авахдаа дараах шалгуурыг үндэслэнэ.

6.1.1. дэлхийн болон үндэсний хэмжээнд нэн ховор, ховор, устах аюулд орсон амьтан, ургамлын голомт нутаг;

6.1.2. байгалийн онгон байдал, унаган төрхөө хадгалсан газар нутаг;

6.1.3. үндэсний болон бүс нутгийн экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий газар нутаг;

6.1.4. үндэсний болон бүс нутгийн хэмжээнд онцгой ач холбогдол бүхий цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх;

6.1.5. шинжлэх ухаан, танин мэдэхүйн онцгой ач холбогдол бүхий газар нутаг.

7 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газар

7.1. Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, экосистемийн цогц байдлыг агуулсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.

8 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авах шалгуур үзүүлэлт

8.1. Газар нутгийг байгалийн цогцолборт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авахдаа дараах шалгуурыг үндэслэнэ.

8.1.1. байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, байгалийн бүс, бүслүүр, экосистемийн төлөөлөл бүхий газар нутаг;

8.1.2. байгаль, соёлын өв, өвөрмөц тогтоц бүхий газар нутаг;

8.1.3. үндэсний болон бүс нутгийн хэмжээнд ач холбогдол бүхий цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх;

8.1.4. нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац нутаг;

8.1.5. экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад ач холбогдол бүхий газар нутаг;

8.1.6. үндэсний болон бүс нутгийн хэмжээний аялал жуулчлалын түшиц газар нутаг.

9 дүгээр зүйл. Байгалийн нөөц газар

9.1. Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, зохистой ашиглах, байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ.

10 дугаар зүйл. Байгалийн нөөц газрын ангиллаар тусгай хамгаалалтанд авах шалгуур үзүүлэлт

10.1. Газар нутгийг байгалийн нөөц газрын ангиллаар тусгай хамгаалалтад авахдаа дараах шалгуурыг үндэслэнэ.

10.1.1. байгалийн онцлог хэв шинжийг унаган төрхөөр нь хадгалах, байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг зохистой ашиглах шаардлага бүхий газар нутаг;

10.1.2. ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих, нүүдэллэн шилжих нөхцөлийг бүрдүүлэх газар нутаг;

10.1.3. эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах шаардлага бүхий газар нутаг;

10.1.4. газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах шаардлагатай геологийн нөөц бүхий газар;

10.1.5. гол мөрний урсац бүрэлдэх эх, стратегийн ач холбогдол бүхий гадаргын болон гүний цэнгэг усны нөөц, олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар;

10.1.6. онцлон хамгаалах шаардлагатай баянбүрд, заган болон төгөл ой бүхий газар;

10.1.7. хүн амын болон үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор үүцлэх шаардлагатай газар нутаг;

10.1.8. нөхөн сэргээх шаардлагатай доройтсон орчин бүхий газар.

11 дүгээр зүйл. Дурсгалт газар

11.1. Байгалийн болон соёлын өвийн унаган төрх, үнэт зүйлийн язгуур шинжийг хадгалах, өвлөн үлдээх зорилгоор тусгай хамгаалалтад авсан үндэсний болон олон улсын ач холбогдол бүхий газар нутгийг дурсгалт газар гэнэ.

11.2. Дурсгалт газар нь дараах төрөлтэй байна:

11.2.1. байгалийн дурсгалт газар;

11.2.2. соёлын өвийн дурсгалт газар.

11.3. Энэ хуулийн 11.2.2-т заасан дурсгалт газрыг хамгаалахтай холбогдсон харилцааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар^[6] зохицуулна.

11.4. Энэ хуулийн 11.2.2-т заасан дурсгалт газар нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газрын ангилал бүхий тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн зааг дотор байгаа тохиолдолд түүний хамгаалалтын менежментийг энэ хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл. Дурсгалт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авах шалгуур үзүүлэлт

12.1. Газар нутгийг байгалийн дурсгалт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авахдаа дараах шалгуурыг үндэслэнэ.

12.1.1. байгалийн өвөрмөц тогтоц, илэрц бүхий хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, элсэн манхан бүхий газар;

12.1.2. өвөрмөц тогтоц бүхий галт уулын тогоо, өрх болон солир, солирын цар;

12.1.3. экосистемийн ач холбогдол бүхий төгөл мод, рашаан булаг, баянбүрд бүхий газар нутаг;

12.1.4. Соёлын биет болон биет бус өвийн байгаль орчин, уламжлалт ахуйтай харилцан шүтэлцэж хадгалагдсан газар нутаг.

12.2. Соёлын өвийн дурсгалт газар гэж Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн^[7] 3.1.6-д заасан газрыг ойлгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ДОТООД БҮС,

ХАМГААЛАЛТЫН ДЭГЛЭМ, ГОРИМ

13 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газрын дотоод бүс

13.1. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газар нь дотоод бүстэй байх ба бусад ангиллын тусгай хамгаалалттай газарт дотоод бүс тогтоож болно.

13.2. Тусгай хамгаалалттай газар нь дараах дотоод бүстэй байна:

13.2.1. онгон бүс;

13.2.2. хамгаалалтын бүс;

13.2.3. хязгаарлалтын бүс.

13.3. Улсын тусгай хамгаалалттай газрын дотоод бүс болон байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газрын хамгаалалтын дэглэмийг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын дотоод бүс, түүний хамгаалалтын дэглэмийг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

13.4. Дархан цаазат газрын дотоод бүсийг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан тогтооно.

13.5. Байгалийн цогцолборт газрын дотоод бүсийг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, соёлын өвийг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан тогтооно.

13.6. Тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсийг тогтооходоо мэргэжлийн байгууллагын судалгаа, дүгнэлтийг үндэслэнэ.

14 дүгээр зүйл. Дархан цаазат газрын онгон бүсийн дэглэм

14.1. Онгон бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж зөвхөн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлнэ.

14.2. Онгон бүсэд байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болно.

15 дугаар зүйл. Дархан цаазат газрын хамгаалалтын бүсийн дэглэм

15.1. Хамгаалалтын бүс нь онгон бүсийн хамгаалалтыг бэхжүүлэх, түүнд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах зорилготой ба хамгаалалтын бүсэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

15.1.1. хамгаалалтын бүсэд ургамал, амьтны аймгийн өсөж үржих нөхцөлийг хангах, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, био техникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлэх;

15.1.2. тухайн дархан цаазат газрын хамгаалалтын горим, тогтоосон зам, чиглэлийн дагуу аялал зохион байгуулах;

15.1.3. тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлтэй ажиглалт, судалгаа шинжилгээ хийх.

16 дугаар зүйл. Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн дэглэм

16.1. Хязгаарлалтын бүсэд энэ хуулийн 15 дугаар зүйлд зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

16.1.1. ойд арчилгаа, цэвэрлэгээний ажлыг зохих зөвшөөрөлтэй хийх;

16.1.2. ан амьтны сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг зохих зөвшөөрөлтэй явуулах;

16.1.3. рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ахуйн зориулалтаар ашиглах;

16.1.4. хяналт шалгалт, судалгаа шинжилгээний зориулалтаар орон байр барих ;

16.1.5. зураг авах, дуу болон дүрс бичлэг хийх, уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх;

16.1.6. нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамал түүх;

16.1.7. тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлтэйгөөр өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны зориулалттай хашаа, саравч барих;

16.1.8. зохих зөвшөөлтэй ахуйн зориулалтаар загасчлах.

17 дугаар зүйл. Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа

17.1. Дархан цаазат газарт энэ хуулийн 16 дугаар зүйлд зааснаас бусад дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

17.1.1. тэсэлгээ хийх, ашигт малтмал, газрын тос, занар, байгалийн хий, цацраг идэвхт бодис эрэх, хайх, ашиглах, хадгалах, геологийн судалгаа хийх, байгалийн төлөв байдлыг өөрчлөх;

17.1.2. хөнөөлт шавж, мэрэгч, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник хэрэгсэл, бодис ашиглан хэрэгжүүлэх;

17.1.3. өвчин үүсгэгч, хөнөөлт шавж, харь болон унаган бус зүйлийн амьтан, ургамал нутагшуулах;

17.1.4. байгаль, соёлын өвийг зөвшөөрөлгүй шилжүүлэх, ухах, малтах;

17.1.5. хамгаалалтын болон дэд бүтцийн байгууламж, таних тэмдэг, тэмдэглэгээг гэмтээх, өөр газарт шилжүүлэх, халхлах;

17.1.6. металл хайгч, химийн хорт болон тэсрэх бодис авч явах, ашиглах;

17.1.7. тухайн хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүй хийн буу болон галт зэвсэг, анч нохой, бүргэд авч явах, ашиглах;

17.1.8. байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний, техникийн зориулалттай ургамал, мод, сөөг, заг, зэгс, шагшуурга зэргийг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх;

17.1.9. хөрс, ус, агаар, орчныг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;

17.1.10. онцгой нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх;

17.1.11. энэ хуулийн 16.1.2-т зааснаас бусад зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүхийг эвдэж сүйтгэх, устгах, шилжүүлэх зэргээр амьдрах орчныг нь өөрчлөх;

17.1.12. тухайн газрын байгалийн төрхийг өөрчлөх, экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулах, нэн ховор, ховор амьтан, ургамлын голомт, тархац нутаг, шилжилт нүүдлийг таслах, дархан цаазат газрын онгон байдал, унаган төрхийг алдагдуулахаар авто болон төмөр зам, замын байгууламж барих, засах;

17.1.13. зөвшөөрөлгүй мал бэлчээрлүүлэх;

17.1.14. мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм болон газрын доорх усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;

17.1.15. хязгаарлалтын бүсээс бусад бүсэд хамгаалалт, судалгаа шинжилгээ, аялал жуулчлалын зориулалтаас бусад барилга байгууламж барих;

17.1.16. хууль тогтоомж болон хамгаалалтын дэглэм, горимоор хориглосон, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах.

18 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газрын онгон бүсийн дэглэм

18.1. Онгон бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсөж үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авах.

19 дүгээр зүйл. Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын бүсийн дэглэм

19.1. Хамгаалалтын бүсэд байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэй дараах үйл ажиллагаа явуулж болно:

19.1.1. энэ хуулийн 16, 18 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа;

20 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсийн дэглэм

20.1. Хязгаарлалтын бүсэд энэ хуулийн 19 дүгээр зүйлд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулж болно:

20.1.1. уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх;

20.1.2. батлагдсан зураг төсөл, стандартын дагуу авто зам, замын байгууламж барих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах;

20.1.3. биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засаж тохижуулах;

20.1.4. тухайн нутаг дэвсгэр дэх сууринг ногоон хөгжлийн бодлого зарчимд нийцсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийн дагуу хөгжүүлэх.

21 дүгээр зүйл. Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа

21.1. Байгалийн цогцолборт газарт энэ хуулийн 20 дугаар зүйлд зааснаас бусад дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

21.1.1. энэ хуулийн 17.1.1-17.1.13-т заасан үйл ажиллагаа явуулах;

21.1.2. онгон бүсэд хамгаалалт, судалгаа шинжилгээний зориулалтаас бусад барилга байгууламж барих;

21.1.3. батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж барилга байгууламж барих, суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх.

22 дугаар зүйл Байгалийн нөөц газрын дэглэм

22.1. Байгалийн нөөц газарт дараах үйл ажиллагаа явуулж болно:

22.1.1. тухайн газрын байгалийн хэв шинж, төрх байдал, амьтан, ургамлын өсөлт, үржилт, тархац нутаг, нүүдлийн замд сөрөг нөлөөгүйгээр энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулах;

22.1.2. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт, нөөц даацын судалгаа, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд заасны дагуу байгалийн нөөц, ой, ургамал, ан амьтныг зохистой ашиглах;

22.2. Байгалийн нөөц газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

22.2.1. тухайн газрын хамгаалалт, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх барилга, байгууламж барих;

22.2.2. ашигт малтмал, газрын тос, занар, байгалийн хий, цацраг идэвхт бодис эрэх, хайх, ашиглах;

22.2.3. зохих судалгаа, зөвшөөрөлгүй ан амьтан агнах, барих, байгалийн нөөц ашиглах;

22.2.4. гадаргын болон газрын доорх усыг бохирдуулах, байгалийн унаган төрхийг өөрчлөх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

23 дугаар зүйл. Байгалийн дурсгалт газрын хамгаалалтын дэглэм

23.1. Байгалийн дурсгалт газарт дараах үйл ажиллагаа явуулж болно:

23.1.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүгнэлт, нөөц даацын судалгаа, менежментийн төлөвлөгөөг үндэслэн зохих зөвшөөрөлтэйгөөр байгалийн нөөцийг зохистой ашиглах;

23.1.2. аялал жуулчлал, уламжлалт зан үйл, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах;

23.1.3. байгаль, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх;

23.1.4. байгалийн гамшиг, ой хээрийн түймэр, хөнөөлт шавжтай тэмцэх, хамгаалах арга хэмжээг байгальд халгүй арга хэрэгслэлээр хэрэгжүүлэх.

23.2. Байгалийн дурсгалт газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

23.2.1. байгалийн дурсгалт зүйлээс 1.0 километрийн дотор бараа сүрийг нь дарах барилга байгууламж барих;

23.2.2. байгалийн дурсгалт газрын хилийн заагаас гадагш 5.0 километрээс багагүй зайд тэсэлгээ хийх;

23.2.3. байгалийн дурсгалт газрыг хөндөх, ухах тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулах.

24 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горим

24.1. Тусгай хамгаалалттай газар нь хамгаалалтын дэглэмийн хүрээнд тухайн газар нутгийн байгаль, нийгэм, эдийн засгийн онцлог, орон нутгийн уламжлалт соёл, зан, заншлыг харгалзан тогтоосон хамгаалалтын горимтой байж болно.

24.2. Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын горимыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын горимыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

24.3. Тухайн тусгай хамгаалалттай газар нутаг нь дэлхийн байгаль, соёлын өвийн жагсаалт, Хүн ба Шим мандлын нөөц газрын сүлжээ болон Рамсарын конвенцийн хавсралтад бүртгэгдсэн бол тухайн газрын хамгаалалтын горимд холбогдох конвенцийн заалтыг мөрдлөг болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮС

25 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс

25.1. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газар нь орчны бүстэй байна.

25.2. Байгалийн нөөц газар болон дурсгалт газарт орчны бүс тогтоож болно.

25.3. Орчны бүс нь тусгай хамгаалалттай газрын хилийн заагийн гадна байна.

26 дугаар зүйл. Орчны бүсийг тогтоох шалгуур үзүүлэлт

26.1. Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тогтоохдоо дараах шалгуурыг үндэслэнэ:

26.1.1. байгалийн ургамал, зэрлэг амьтны тархац нутаг, тэдгээрийн нүүдэллэх, шилжих зам, нутагшиж болох газар нутаг;

26.1.2. байгалийн нөөцийн ашиглалт нь тухайн тусгай хамгаалалттай газрын экосистемийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй газар нутаг;

26.1.3. тусгай хамгаалалттай газрын экосистемд нөлөөлөх ой, гол, голын эх, сав газар;

26.1.4. байгаль орчныг бохирдуулах эх үүсвэрийн байршил, нөлөөллийн цар хүрээ;

26.1.5. нийгэм, эдийн засгийн хөгжил нь тухайн тусгай хамгаалалттай газар, түүний орчны байгаль, байгалийн нөөцөөс онцгой хамаарал бүхий суурин газар;

26.1.6. байгалийн өвөрмөц тогтоц, соёлын өвийн дурсгал бүхий газар;

26.1.7. хэт доройтсон, нөхөн сэргээх шаардлагатай газар нутаг.

27 дугаар зүйл. Орчны бүсийн хилийн заагийг тогтоох

27.1. Тухайн газрыг тусгай хамгаалалтад авснаас хойш нэг жилийн дотор сум, дүүргийн Засаг дарга, хамгаалалтын захиргаа энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан шалгуурын дагуу орчны бүсийн хилийн заагийг тогтоох тухай санал боловсруулж, тухайн сум, дүүргийн иргэдээр хэлэлцүүлэн тэдний саналыг тусгаж, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилна.

27.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн хилийн заагийг тогтоох тухай Засаг даргын саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

27.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орчны бүс тогтоосон үндэслэл, холбогдох мэдээлэл, хилийн заагийн 1:200000 масштабын газрын зургийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

27.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн хилийн заагийг тухайн газар нутгийг тусгай хамгаалалтад авснаас хойш нэг жилийн дотор тогтоосон байна.

28 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн дэд хөтөлбөр

28.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд хамрагдсан сум, дүүрэг нь орчны бүсийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн[8] 18.1.2./з/-д заасан цогцолбор хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлнэ.

28.2. Орчны бүсийн дэд хөтөлбөрийг тухайн сум, дүүргийн Засаг дарга хамгаалалтын захиргаатай хамтран боловсруулж, сумын иргэд, орчны бүсийн зөвлөлөөр хэлэлцүүлэн тэдний саналыг тусгаж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хэрэгжүүлнэ.

28.3. Орчны бүсийн дэд хөтөлбөрт дараах зүйлийг тусгана:

28.3.1. орчны бүсийн байгаль, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлж буй болон үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээ;

28.3.2. орчны бүсэд байгальд халгүй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, цэвэр үйлдвэрлэл, эко-бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл, хөтөлбөрийг дэмжих арга хэмжээ;

28.3.3. орчны бүс, тусгай хамгаалалттай газар нутагт ан амьтан, ургамал, газар, ой, ус, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээх арга хэмжээ;

28.3.4. орчны бүсээр дамжин өнгөрдөг ан амьтдын нүүдэллэх зам, өсөж үржих орчныг хамгаалах арга хэмжээ;

28.3.5. орчны бүсийн байгаль, нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд талуудын үүрэг, хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны боловсрол олгоход чиглэсэн арга хэмжээ;

28.3.6. орчны бүсийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал, санхүүжүүлэх эх үүсвэр, хэрэгжилтийг хянах, үнэлэх тогтолцоог тусгана.

29 дугаар зүйл. Орчны бүсийн зөвлөл

29.1. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа сум, дүүргийн Засаг дарга хамтран орчны бүсийн дэд хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах, талуудын үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж өгөх, хяналт тавих, олон талын оролцоог хангах үүрэг бүхий орон тооны бус Орчны бүсийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/- ийг байгуулна.

29.2. Зөвлөл нь сондгой тооны гишүүдтэй байх ба дараах бүрэлдэхүүнтэй байна:

- 29.2.1. сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёр төлөөлөл;
- 29.2.2. нутгийн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн гурваас доошгүй төлөөлөл;
- 29.2.3. тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны нэг төлөөлөл;
- 29.2.4. тухайн бүс дэх усны сав газрын захиргааны нэг төлөөлөл;
- 29.2.5. байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын хоёр төлөөлөл;
- 29.2.6. тухайн бүсэд байгалийн нөөц ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн хоёр төлөөлөл;
- 29.2.7. зөвлөлийг гишүүдийн дундаас сонгогдсон дарга удирдана.
- 29.3. Зөвлөлийн даргын санал болгосноор нарийн бичгийн даргыг томилох ба нарийн бичгийн дарга нь орон тооны байж болно.
- 29.4. Орчны бүсийн зөвлөл байгуулах, ажиллах журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
- 29.5. Зөвлөл дараах эрх, үүрэгтэй байна:
- 29.5.1. энэ хуулийн 39.2-т заасан тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн зарчмыг хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцогч талуудын үүрэг, хариуцлага, оролцоог хангахад сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад зөвлөх;
- 29.5.2. тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг зохион байгуулах;
- 29.5.3. орчны бүсийн дэд хөтөлбөрийг тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, сум, дүүргийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 29.5.4. орчны бүсийн сангийн үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- 29.5.5. орчны бүсэд байгаль, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хамгаалах чиглэлээр олон нийтийн санаачилгыг өрнүүлэх, энэ чиглэлээр сум, дүүргийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;
- 29.5.6. зөвлөлийн үйл ажиллагаа, үр дүн, сангийн төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг гаргаж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнах.

30 дугаар зүйл. Орчны бүсийн сан

- 30.1. Зөвлөл нь орчны бүсийн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг дэмжих зорилгоор Орчны бүсийн санг байгуулж ажиллана.
- 30.2. Орчны бүсийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
- 30.2.1. сум, дүүрэгт байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 10-аас доошгүй хувь;
- 30.2.2. орчны бүсэд байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогын 10-аас доошгүй хувь;
- 30.2.3. орчны бүсэд ус бохирдуулсны төлбөрийн орлогын 10-аас доошгүй хувь;

30.2.4. орчны бүсэд байгаль орчны хууль тогтоомж зөрчсөнөөс захиргааны журмаар хураагдсан эд зүйлсийг борлуулсны орлогын 20 хувь;

30.2.5. тухайн орчны бүсээс сумын нийгэм, эдийн засагт үзүүлж буй экосистемийн үйлчилгээний төлбөрийн тодорхой хувь;

30.2.6. иргэд, байгууллагын хандив, тусламж;

30.2.7. орчны бүсийн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны орлого;

30.2.8. орчны бүсийн сангаас олгосон жижиг зээлийн хүүгийн орлого;

30.2.9. бусад орлого.

30.3. Энэ хуулийн 30.2.5-30.2.9-т заасан орлогоос уг санд төвлөрүүлэх хувь хэмжээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох ба Зөвлөл нь тухайн сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн зарцуулна.

30.4. Орчны бүсийн сангийн хөрөнгийг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг дэмжих арга хэмжээнд зарцуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТАЛААРХ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

31 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

31.1. Улсын Их Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1. тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлогыг тодорхойлох;

31.1.2. Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг энэ хуулийн 4.2-т заасан ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах, ангиллыг өөрчлөх, тэдгээрийн хилийн заагийг батлах;

31.1.3. газар нутгийг тусгай хамгаалалтаас гаргах асуудлыг хууль гаргаж шийдвэрлэх.

32 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

32.1. Засгийн газар тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1. газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, ангиллыг өөрчлөх, тэдгээрийн хилийн заагийг тогтоох саналыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих;

32.1.2. тусгай хамгаалалттай газар нутгийн талаар баримтлах төрийн бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

32.1.3. тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах эдийн засаг, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг зохицуулах

32.1.4. тусгай хамгаалалттай газар нутгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгах талаарх салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулж, шаардлагатай арга хэмжээ авах;

32.1.5. тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийг хөгжүүлэх төрийн бодлогыг баталж, хэрэгжүүлэх;

32.1.6. тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчийн хариуцан хамгаалах талбайн хэмжээг батлах;

32.1.7. газар нутгийг тусгай хамгаалалтад авах журмыг батлах;

32.1.8. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах журмыг батлах;

32.1.9. тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах төсөл сонгон шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журам батлах;

32.1.10. улсын тусгай хамгаалалттай газарт хамгаалалтын захиргаа байгуулах, өөрчлөх, татан буулгах;

32.1.11. улсын тусгай хамгаалалттай газрын экосистемийн үйлчилгээний үнэлгээ, төлбөрийн хэмжээг тогтоох

32.1.12. хуульд заасан бусад.

33 дүгээр зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

33.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1. тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

33.1.2. тусгай хамгаалалттай газар нутгийг дэлхийн өв болон Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийн хавсралтад бүртгүүлэх, хүлээсэн үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангах, тайлагнах;

33.1.3. газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, ангиллыг өөрчлөх, тэдгээрийн хилийн заагийг тогтоох үндэслэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авч боловсруулан Засгийн газарт оруулах;

33.1.4. тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг нэгдмэл удирдлага, мэдээллээр хангах, менежментийн үр дүнд хяналт тавих;

33.1.5. тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэхэд төр, иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийн хамтын ажиллагааг хангах;

33.1.6. улсын тусгай хамгаалалттай газрын дэглэм, горимыг мөрдүүлэх, хяналт тавих;

33.1.7. тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах журам, гэрээ, гэрчилгээний загвар батлах;

33.1.8. улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, менежментийн үр ашигт байдлыг үнэлэх, хариуцлага тооцож, урамшуулах;

33.1.9. тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа шинжилгээ явуулах журам батлах;

33.1.10. улсын тусгай хамгаалалттай газарт ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх, агнах, барих амьтны тоо, хэмжээг тогтоох;

33.1.11.улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;

33.1.12.хамгаалалтын менежментийг нь гэрээгээр хариуцуулснаас бусад улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны даргыг томилж, чөлөөлөх;

33.1.13.тусгай хамгаалалттай газар нутгийн хүний нөөцийг мэргэшүүлэх, сургалт, сурталчилгаа, судалгааны бүсийн төв байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;

33.1.14.тусгай хамгаалалттай газар нутгийн тогтвортой санхүүжилтийг бүрдүүлэх зорилгоор байгаль хамгаалах сангийн хүрээнд Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тусгай хамгаалалттай газар нутгийн хөгжлийн данс нээж ажиллуулах;

33.1.15.тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх, үйлчилгээ эрхлэх, хөлс төлөх журам

33.1.16.газар нутгийг тусгай хамгаалалтад авах, хилийн заагийг тогтоох, баталгаажуулах, газрын нэгдмэл санд өөрчлөлт оруулах ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;

33.1.17.тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлт болон бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний уялдааг хангах;

33.1.18.тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний мэдээлэл болон тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах талаар гарсан шийдвэрийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлэх;

33.1.19.тусгай хамгаалалттай газар нутагт палентлоги, архелогийн болон олон улсын судалгаа шинжилгээний ажил явуулах, амралт сувилал, аялал жуулчлал эрхлэх, зам, дэд бүтцийн байгууламж барих, засварлах, өргөтгөх талаар зөвшөөрөл олгох;

33.1.20.газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан үндэслэлийг хянаж, хуульд нийцээгүй тохиолдолд тухайн шийдвэрийг цуцлуулах асуудлыг тухайн дээд шатны байгууллагаар нь шийдвэрлүүлэх;

33.1.21.тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа ажилтан, байгаль хамгаалагчийн хэрэглэх галт зэвсэг, агсамж, нэг бүрийн тусгай хэрэгслэлийн төрөл, тэдгээрийг хэрэглэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллагатай хамтран батлах;

33.1.22.идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, урамшуулах журмыг батлах;

33.1.23.хуульд заасан бусад.

34 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

34.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.1.1. харьяалах нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах, ангиллыг өөрчлөх, хилийн заагийг тогтоох саналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

34.1.2. харьяалах нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах, ангиллыг өөрчлөх, хилийн зааг, дэглэмийг батлах;

34.1.3. харьяалах нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутаг, орчны бүсэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Засаг дарга, хамгаалалтын захиргааны даргын тайланг хэлэлцэх;

34.1.4. тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн дэд хөтөлбөрийг Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2./з/-д заасан цогцолбор хөтөлбөрт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг жил бүр баталж, хяналт тавих;

34.1.5. орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг батлах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг орон нутгийн төсөвт тусгах;

34.1.6. орчны бүсийн сангийн журмыг баталж, зарцуулалтад хяналт тавих;

34.1.7. хууль тогтоомжид заасан бусад.

35 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

35.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тусгай хамгаалалттай газар нутгийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1. тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

35.1.2. харьяалах нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг тусгай хамгаалалтад авах, ангиллыг өөрчлөх, хилийн заагийг тогтоох саналыг энэ хуулийн 10, 12 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт болон судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барих;

35.1.3. орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;

35.1.4. харьяалах нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутагт гарсан гал түймэр, байгалийн гамшгийн хор уршгийг таслан зогсоох, арилгах арга хэмжээнд хөрөнгө, хүн хүч, техник гаргах, дайчлан ажиллуулах, зохион байгуулах;

35.1.5. орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, орчны бүсийн дэд хөтөлбөрийг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, батлуулах;

35.1.6. орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, орчны бүсийн хөгжлийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг боловсруулж, батлуулах;

35.1.7. газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан үндэслэл, тухайн газрын мэдээллийг бүрдүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

35.1.8. хууль тогтоомжид заасан бусад.

36 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны бүрэн эрх

36.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа /цаашид "хамгаалалтын захиргаа" гэх/ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1. тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомж, хамгаалалтын дэглэм, горимын хэрэгжүүлэх;

36.1.2. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

36.1.3. тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, судалгааны тайлан, үр дүнг хүлээн авах;

36.1.4. тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горимд нийцүүлэн амьтны сүргийн бүтцийг зохицуулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, ойд арчилгаа, цэвэрлэгээ, ойжуулалт хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

36.1.5. амьтанд зориулан ус задгайлах, хадлан бэлтгэх, өвс тэжээл, хужир, шүү тавих, нөмөр хорго барих болон хамгаалах бусад арга хэмжээг гүйцэтгэх;

36.1.6. тусгай хамгаалалттай газар нутагт явуулах аялал жуулчлалын зам, чиглэлийг батлах, аяллын жим, түр отоглох цэг, тэмдэг, тэмдэгжүүлэлтийг стандартын дагуу хийх, засаж тохижуулах;

36.1.7. байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, орчны бүсийн дэд хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнд зарцуулах төсвийг Засаг даргатай хамтран боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, батлуулах;

36.1.8. улсын тусгай хамгаалалттай газрын мэдээллийг бүрдүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

36.1.9. зөвшөөрөгдсөн бүсэд авто зам, гүүр, дэд бүтэц, барилга байгууламж барих ажлыг зориулалт, батлагдсан зураг, стандарт, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;

36.1.10. тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд байгалийн гамшиг, ган зуд тохиолдсон үед, хамгаалалтын дэглэм, горим, бэлчээрийн нөөц даацад нийцүүлэн зөвшөөрлийн дагуу уламжлалт аргаар мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх ажлыг гэрээний үндсэн дээр зохион байгуулах;

36.1.11. хөнөөлт шавж, мэрэгч, түймрээс урьдчилан сэргийлэх, байгалийн гамшиг, амьтан, ургамлын өвчин, гэнэтийн бусад аюулаас тусгай хамгаалалттай газар нутагт учирсан хор уршгийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

36.1.12. тухайн газар нутгийн хамгаалалтын дэглэм, горимын болон менежментийн төлөвлөгөөний хүрээнд явуулж болох дараах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих:

36.1.12.а. аялал жуулчлалын тогтоосон зам, чиглэлийн дагуу завь, моторт завь, усан онгоц, авто болон ердийн хөсгөөр буюу явганаар аялах, уулын авиралт хийх;

36.1.12.б. байгалийн дагалт баялаг ашиглах, уламжлалт мал аж ахуй эрхлэх, мал бэлчээрлүүлэх, оторлуулах, өвөлжөө, хаваржааны саравч барих;

36.1.12.в. сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн хадлангийн талбайг зохистой ашиглуулах;

36.1.12.г. аялагч жуулчдад үйлчилгээ үзүүлэх;

36.1.12.д. рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай эрдэс, байгалийн дагалт баялгийг ашиглах;

36.1.12.е. уул овоо тахих, уламжлалт зан үйлийг байгальд халгүй хэлбэрээр үйлдэх;

36.1.12.ё. тусгай хамгаалалттай газарт худаг гаргах;

36.1.12.ж. шинжлэх ухаан болон арилжааны зориулалтаар зураг авах, дүрс бичлэг хийх;

36.1.12.з. ажиглалт, судалгаа, шинжилгээ хийх

36.1.12.и. олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах;

36.1.13. тусгай хамгаалалттай газарт газар ашиглах эрх бүхий иргэн, хуулийн этгээдтэй газар ашиглах гэрээ байгуулан, гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавин, дүгнэлт гаргах;

36.1.14. тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгогдсон, дуусгавар болсон, хугацаа сунгагдсан, газар ашиглах эрх хүчингүй болсон тухай бүрт гэрээ, гэрчилгээний хуулбар, холбогдох мэдээллийг аймаг, сум, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн албанд хүргүүлэх;

36.1.15. тусгай хамгаалалттай газар нутгийн болон бусад хууль тогтоомж, журам, хамгаалалтын дэглэм, горим, гэрээний үүргээ зөрчсөн иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийн газар, байгалийн нөөц ашиглах эрх, зөвшөөрөл, үйл ажиллагааг хязгаарлах, тодорхой хугацаагаар болон бүр мөсөн зогсоож, зөвшөөрлийг цуцлуулах талаар санал, үндэслэл боловсруулж хуулийн дагуу шийдвэрлэх;

36.1.16. байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг батлагдсан загвар бүхий үнэмлэх, баталгааны тэмдэг, дүрэмт хувцас, ялгах тэмдэг, хяналт шалгалтын хэвлэмэл хуудас, техник хэрэгслэл, нэг бүрийн тусгай хэрэгсэл, холбоо, уналга, тээврийн хэрэгсэл, ажлын байр, ажиллах нөхцөл болон энэ хуулийн 33.1.21-т заасан журмын дагуу галт зэвсэг, агсамжаар хангах;

36.1.17. хуульд заасан бусад эрх.

37 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны ажилтан, байгаль хамгаалагчийн эрх, үүрэг

37.1. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны ажилтан, байгаль хамгаалагч, нь батлагдсан загвар бүхий үнэмлэх, баталгааны тэмдэг, дүрэмт хувцас, ялгах тэмдэг, хяналт шалгалтын хэвлэмэл хуудас, техник хэрэгслэл, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дүрс, дуу бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамж, уналга, тээврийн хэрэгсэл, ажлын байр, ажиллах нөхцөлөөр хангагдсан байна.

37.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны ажилтан, байгаль хамгаалагчийн хэрэглэх галт зэвсэг, агсамж, нэг бүрийн тусгай хэрэгслэлээр хангагдсан байна.

37.3. Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны ажилтан, байгаль хамгаалагч нь Төрийн албаны тухай хуулийн^[9] тавдугаар бүлэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн^[10] 29¹ дүгээр зүйлд заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжээс гадна дор дурдсан нэмэгдэл баталгаагаар хангагдана:

37.3.1. гэнэтийн ослын болон амь насны даатгалд хамруулах;

37.3.2. хээрийн нөхцөлийн 20 хувийн нэмэгдэл олгох;

37.3.3. бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн, дарамталсан, амь нас, эрүүл мэндэд нь бодит аюул заналхийлсэн тохиолдолд цагдаагийн байгууллагаар аюулгүй байдлаа хангуулах;

37.3.4. тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллаж байгаа байгаль хамгаалагчид 5 жил тутамд 12 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох.

37.4. Энэ хуулийн 37.3.1 -т заасан даатгалын хураамжийг төр хариуцна.

37.5. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, мэдээлэл сурталчилгаа, ажиглалт, мониторинг хийх, хяналт тавихад туслах чиг үүрэг бүхий идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж болно.

37.6. энэ хууль болон байгаль орчныг хамгаалах бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх;

37.7. хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, шалгалт хийх;

37.8. хууль тогтоомж зөрчсөн сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, түр хураах, шаардлагатай гэж үзвэл унаа хөсөгт нь үзлэг хийх, зэвсэг хэрэгсэл, агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйлийг хураан авах;

37.9. хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгөх, шаардлага тавих;

37.10. албан үүргээ гүйцэтгэх үедээ дүрэмт хувцас, ялгах тэмдэг, зэвсэг, хэрэгсэлтэй байх.

38 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газарт амьдарч, үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээдийн үүрэг

38.1. Тусгай хамгаалалттай газарт амьдарч, үйл ажиллагаа явуулдаг иргэн, хуулийн этгээд дараах үүрэгтэй:

38.1.1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн[11] 31 дүгээр зүйл, байгаль орчны бусад хууль тогтоомжид заасан үүрэг;

38.1.2. амьдарч буй болон үйл ажиллагаа явуулж буй газартаа тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын дэглэм, горим, стандарт, хууль тогтоомжийн шаардлага, гэрээний үүргийг биелүүлэх, сахиулах, хяналт тавих, орчны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг хангуулах, амьтан ургамлыг хамгаалах.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН МЕНЕЖМЕНТ

39 дүгээр зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн зарчим

39.1. Төр нь байгаль орчин, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдал, байгаль, соёлын өвийн дурсгалыг хадгалан хамгаалж, үе дамжуулан үлдээх зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж түүний менежментийг улс орны болон дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

39.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

39.2.1. тусгай хамгаалалттай газар нутаг нь стратегийн үнэт баялаг байх;

39.2.2. тусгай хамгаалалттай газар нутгийг байгаль хамгаалах төрийн бодлогын цөм, байгаль, соёлын өвийн дурсгалыг хадгалан хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг баталгаажуулах гол үндэс болгон хөгжүүлэх;

39.2.3. тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг төрийн бодлого, дэмжлэг, зохицуулалтаар тогтвортой хөгжүүлэх;

39.2.4. тусгай хамгаалалттай газар нутгийн хязгаарлалтын болон орчны бүс нутгийг ногоон хөгжлийн түшиц, загвар, эко бүс нутаг болгон хөгжүүлэх;

39.2.5. тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн нөөцийн ашиглалтыг тухайн газрын экологи-эдийн засгийн үнэлгээ, байгаль орчны даацад нийцсэн байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр явуулах;

39.2.6. тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент нь тухайн газрын байгаль, нийгэм, эдийн засаг болон нөөц, даацын судалгаанд үндэслэх;

39.2.7. байгалийн нөөц ашигласны төлбөрийн болон байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогын тодорхой хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд зарцуулах;

39.2.8. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн санхүүжилтийн тогтвортой байдлыг төрөөс баталгаажуулж, бусад талууд болон хувийн хэвшлийн оролцоог дэмжин урамшуулах;

39.2.9. тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний менежментийн үр ашиг, үр нөлөөнд тогтмол хугацаанд мониторинг хийж,сайжруулах;

39.2.10. тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлт, хэрэгжилт нь оролцогч талуудын сонирхол, эрх ашиг, үүрэг хариуцлагыг уялдуулсан хамтын менежментийн зарчимд тулгуурлах;

39.2.11. тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь орчин үеийн шаардлага, эрэлт хэрэгцээг хангасан бүтэц, удирдлага, зохион байгуулалттай, ил тод байдлыг хангасан сайн засаглалтай байх;

39.2.12. тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг хөгжүүлэхэд гадаад улс орнууд, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

40 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө

40.1. Тусгай хамгаалалттай газар нутаг бүр менежментийн болон бизнесийн төлөвлөгөөтэй байна.

40.2. Тухайн тусгай хамгаалалттай газарт газар, байгалийн нөөц ашиглалт, хамгаалалтын арга хэмжээ, санхүүжилт, төсвийнхуваарилалтыгменежментийн болон бизнес төлөвлөгөөг үндэслэн шийдвэрлэнэ.

40.3. Менежментийн болон бизнесийн төлөвлөгөөг боловсруулах аргачлал, журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

40.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээ, ажил үйлчилгээг иргэн,байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээд гэрээгээр хэрэгжүүлж болно.

41 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр хариуцуулах

41.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдэд бүхэлд нь буюу хэсэгчлэн хариуцуулж болно.

41.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг 25 жил хүртэлх хугацаагаар хариуцуулж болно. Гэрээний эхний туршилтын хугацаа 5 жил байх ба менежментийн үр нөлөөг үндэслэн 10 жил тутам сунгана.

41.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг гэрээгээр хариуцах байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээд нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр 5-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн, мэргэжлийн боловсон хүчинтэй, санхүүгийн нөөц, эх үүсвэр бүрдүүлэх чадавхтай байна.

42 дугаар зүйл. Улсын хилийн болон хил орчмын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт

42.1. Засгийн газар улсын хилийн болон хил орчмын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулах зорилгоор хөрш орнуудтай хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулж болно.

42.2. Улсын хилийн болон хил орчмын тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон улсын хил хамгаалах байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

42.3. Тусгай хамгаалалттай газар нутагт улсын хилийн болон хил орчмын хэсгийг хамгаалуулах зорилгоор хилийн заставын дарга, туслагчид орон тооны бус байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх олгож болно. Хилийн заставын дарга, туслагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрхийг зөвхөн хилийн бүсэд хэрэгжүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ

ГАЗАР АШИГЛАХ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ЯВУУЛАХ

43 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах

43.1 Улсын тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулахтай холбоотой харилцааг энэ хуулиар, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах харилцааг Газрын тухай хуулиар зохицуулна.

43.2 Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын болон хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газарт Монгол Улсын иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдэд тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр газар ашиглуулж болно.

43.3 Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хуулийн этгээдэд газар ашиглуулахыг хориглоно.

44 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулахад баримтлах зарчим

44.1 Тусгай хамгаалалттай газарт нутагт ашиглуулах боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг урьдчилан тогтоож тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө болон аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

44.2 Энэ хуулийн 44.1-т заасан тухайн жилд ашиглах газрын хэмжээ, байршил, зориулалтыг нийтэд ил тод мэдээлсэн байна.

-

45 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт ашиглах газрын зориулалт, хугацаа

-

45.1 Монгол Улсын иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдэд аялал жуулчлал, амралт сувилал, сургалт, судалгааны төвийн зориулалтаар 5 жилийн хугацаатайгаар гэрээгээр ашиглуулна.

45.2 Улсын тусгай хамгаалалттай газар нутагт байнга оршин суудаг, тухайн засаг захиргааны нэгжид бүртгэлтэй өрхөд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан өвөлжөө, хаваржааны хашаа саравч барих, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарих зориулалтаар 0.1 га хүртэл хэмжээний газрыг тус тус 15 жилийн хугацаатайгаар ашиглуулна.

45.3 Газар ашиглах эрхийн гэрчилгээг нэг удаа сунгах хугацаа 5 жил байна.

-

46 дүгээр зүйл зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах шийдвэр гаргах

-

46.1 Тусгай хамгаалалттай газар нутагт энэ хуулийн 45.1-т заасан зориулалтаар ашиглуулах, шийдвэрийг хамгаалалтын захиргааны саналыг үндэслэн Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, 45.2.-т заасан зориулалтаар газар ашиглуулах шийдвэрийг тухайн сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа гаргана.

46.2 Энэ хуулийн 45.1-т заасан зориулалтаар газар ашиглуулах асуудлыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулж шийдвэрлэнэ.

46.3 Газар ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг Газрын тухай хуулийн^[12] 19.1.5-д заасан аргачлалын дагуу тогтооно.

-

47 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах гэрээ

-

47.1 Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 45.1-т заасан шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг шийдвэр гарснаас хойш 30 хоногт хамгаалалтын захиргаатай хамтран байгуулна.

47.2 газар ашиглах тухай гэрээнд Газрын тухай хуулийн^[13] 34.6-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

47.1.1 тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгө.

47.1.2 газрыг ашиглах, хамгаалах талаарх талуудын эрх, үүрэг, хариуцлага;

47.1.3 гэрээ дуусгавар болсон тохиолдолд газрыг эргүүлж авах нөхцөл, журам, уг газрыг нөхөн сэргээх, засаж тохижуулах, хүлээлгэн өгөх нөхцөл.

47.3 Газрын кадастрын зураг, газрыг хүлээлгэн өгсөн тухай акт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүнд тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь гэрээний салшгүй хэсэг байх ба гэрээний нэгэн адил үйлчилнэ.

-

48 дүгээр зүйл. Газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгах

-

48.1 Газар ашиглагч нь эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хугацааг сунгуулах тухай хүсэлтээ Улсын тусгай хамгаалалттай газарт газар ашиглагч бол Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт газар ашиглагч бол тухайн шатны Засаг даргад гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана:

48.1.1 газар ашиглах эрхийн гэрчилгээ;

48.1.2 газар ашиглах гэрээ, түүний биелэлт;

48.1.3 газрын төлбөр төлсөн баримтын хуулбар;

48.1.4 байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн талаарх тодорхойлолт.

48.2 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн шатны Засаг дарга нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор эрхийн гэрчилгээ, ашиглах нөхцөлийг хангаж ажилласан эсэхийг хянаж, түүнийг хангасан тохиолдолд газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгах шийдвэр гаргана.

48.3 Энэ хуулийн 48.2-д заасан газар ашиглуулах хугацааг сунгах шийдвэрийг үндэслэн хамгаалалтын захиргаа, сумын газрын даамал газрын улсын бүртгэлд бүртгэнэ.

-

49 дугаар зүйл. Газар ашиглагчийн эрх, үүрэг

-

49.1 Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээд нь Газрын тухай хуулийн[14] 35.1.1, 35.1.2, 35.1.5-д зааснаас гадна энэ хуульд заасан үндэслэлээр газраа эргүүлж өгөх тохиолдолд тусгай хамгаалалттай газар нутгаас дахин газар ашиглах эрх эдэлнэ.

49.2 Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээд Газрын тухай хуулийн[15] 35.3.1-35.3.5 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ:

49.2.1 тухайн газрын унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

49.2.2 ашиглах газартаа тогтоосон замаар орж, гарах;

49.2.3 хууль буюу гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, зориулалтын дагуу ашиглах, холбогдох зураг төслөө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах;

49.2.4 дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхдээ холбогдох мэргэжлийн байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэх;

49.2.5 газрын төлбөр, байгалийн нөөц, ус, рашаан ашигласны төлбөрийг газар ашиглах шийдвэр гарснаас эхлэн төлөх;

49.2.6 тухайн ашиглах газраар улс орны стратегийн чухал ач холбогдол бүхий зам, цахилгааны болон дэд бүтцийн шугам сүлжээ дайран өнгөрөх шаардлага гарсан үед тухай газрыг бүхэлд нь болон хэсэгчлэн чөлөөлөх;

49.2.7 газар ашиглах эрх дуусгавар болоход ашиглаж байсан газраа нөхөн сэргээн, засаж тохижуулан хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөх.

-

50 дугаар зүйл. Газар ашиглахтай холбоотой хориглох үйл ажиллагаа

-

50.1 Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглагч нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

50.1.1 ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад худалдах, барьцаалах, түрээслэх, дамжуулан ашиглах, зориулалтыг өөрчлөх;

50.1.2 тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын дэглэмээр хориглосон, гэрээнд зааснаас бусад үйл ажиллагаа явуулах;

50.1.3 гэрээнд заасан газрын хэмжээнээс илүү талбайг хаших, үйл ажиллагаа явуулах, барилга байгууламж барих;

-

51 Газар ашиглах эрх дуусгавар болох, цуцлах, газрыг чөлөөлөх

-

51.1 Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх дараах тохиолдолд дуусгавар болно:

51.1.1 газар ашиглах эрхийн гэрчилгээ болон гэрээний хугацаа дуусахад сунгуулах хүсэлт гаргаагүй;

51.1.2 газар ашиглагч иргэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсон;

51.1.3 тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын дэглэм, горимын хэрэгжилт, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зайлшгүй шаардлага бий болсон.

51.2 Дараах тохиолдолд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засаг дарга газар ашиглах эрхийг цуцална:

51.2.1 газар ашиглагч нь газрын тухай, байгаль орчны тухай хууль тогтоомж, энэ хууль болон газар ашиглуулах гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

51.2.2 газар ашиглагч нь газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй, гэрээнд заасан зориулалтыг өөрчилсөн;

51.2.3 хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 жил дараалан гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй.

51.3 Газар ашиглах эрх дуусгавар болох буюу цуцлагдахад иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээд ашиглаж байсан газраа чөлөөлж энэ хуулийн 47.1-д заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газрыг 90 хоногийн дотор тухайн газар нутгийн хамгаалалтын захиргаанд актаар хүлээлгэн өгнө.

51.4 Газар ашиглагч нь газрыг эргүүлэн хүлээлгэн өгөхдөө тухайн газрын байгаль орчин, газрын хэвлийд учруулсан хохирлыг арилгах, нөхөн сэргээх, газрыг анх хүлээн авсан байдалд оруулахад гарах зардлыг өөрөө хариуцна.

51.5 Газар ашиглах эрх нь цуцлагдсан иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээд газар чөлөөлөх мэдэгдлийг авснаас хойш 90 хоногийн дотор чөлөөлөөгүй тохиолдолд газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Газрыг албадан чөлөөлсөн зардлыг тухайн иргэн, хуулийн этгээдээр нөхөн төлүүлнэ.

51.6 Газар ашиглах эрх дуусгавар болж, 90 хоногийн дотор газраа чөлөөлөөгүй тохиолдолд эрх бүхий байгууллага газар дээрх өмчийг акт үйлдэн шүүхээр баталгаажуулж төрийн өмчид шилжүүлнэ.

-

52 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээ

52.1. Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа шинжилгээний ажил нь байгаль орчны өнөөгийн болон хэтийн төлөв, тухайн газар нутгийн менежментийн үйл ажиллагааны үндэслэлийг тодорхойлох, биологийн олон янз байдлыг судлах, хамгаалах, танин мэдэхүйн мэдээ, баримт цуглуулахад чиглэсэн хөтөлбөртэй байна.

52.2. Энэ хуулийн 52.1-д заасан хөтөлбөрийг тухайн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, дотоод, гадаад, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоотой боловсруулан баталж, хэрэгжүүлнэ.

52.3. Тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа шинжилгээний болон сургалт, сурталчилгааны ажлыг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.

52.4. Энэ хуулийн 52.3.-т заасан бүсчилсэн зохион байгуулалтын бүтцийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан, хэрэгжилтэд хяналт тавина.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН САНХҮҮЖИЛТ

53 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилт

53.1 Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, түүний менежментийг хэрэгжүүлэх арга хэмжээг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

53.2 Энэ хуулийн 53.1-т заасан санхүүжилтээс гадна тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үйлчилгээг сайжруулах замаар дараах төрлийн нэмэлт орлогыг төвлөрүүлэн, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашиг, үйлчилгээний төрлүүдийг нэмэгдүүлэхэд зарцуулна.

53.2.1 тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх болон үйлчилгээ эрхэлсний хөлс;

53.2.2 тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчин, байгалийн нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого;

53.2.3 гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;

53.2.4 иргэн, хуулийн этгээдээс тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын зардлыг санхүүжүүлэх хөрөнгө;

53.2.5 тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үйлчилгээний төлбөр;

53.2.6 хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад орлого

-

54 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах

-

54.1 Энэ хуулийн 53.2-т заасан орлогыг энэ хуулийн 33.1.15 -д заасан дансанд төвлөрүүлнэ.

54.2 Энэ хуулийн 53.1-т заасан эх үүсвэрийг тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх дараах арга хэмжээнд зарцуулна:

54.2.1 байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх;

54.2.2 ой хээрийн түймэр, ойн хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, учирсан хохирлыг арилгах;

54.2.3 доройтсон орчныг нөхөн сэргээх, цэвэрлэх;

54.2.4 эргүүл, хяналт шалгалт, мониторинг хийх;

54.2.5 хамгаалалтын захиргааны хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх;

54.2.6 шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, дэд бүтцийг сайжруулах;

54.2.7 судалгаа, шинжилгээний ажил явуулах, сургалт, сурталчилгаа хийх.

54.3 Энэ хуулийн 53.2.3-д заасан хандив, тусламжийн хөрөнгийг тодорхой зориулалт зааж хандивласан буюу олгосон бол тухайн зориулалтаар нь ашиглана.

54.4 Энэ хуулийн 53.2-т заасан орлогоос тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашгийг нэмэгдүүлэхэд зарцуулах, тайлагнах журмыг Байгаль орчны болон Төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

55 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг

55.1 Тусгай хамгаалалттай газар нутаг түүний орчны бүсэд байгаль орчныг хамгаалах, түүний нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, өсгөн арвижуулах ажилд хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй арга, шинэ санаа, санаачилга нэвтрүүлсэн иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдэд хөнгөлөлттэй зээл олгох замаар урамшуулна.

55.2 Тусгай хамгаалалттай газар нутаг түүний орчны бүсэд байгалийн нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах, дахин боловсруулах дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, хуулийн этгээдэд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогоос санхүүгийн урамшуулал үзүүлнэ.

55.3 Энэ хуулийн 55.1, 55.2-т заасан иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээдийг урамшуулах журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн Төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТАВИХ ХЯНАЛТ

56 дугаар зүйл. Төрийн хяналт

56.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хамгаалалтын захиргаа, мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч хяналт тавина.

56.2 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн албан хаагч, хамгаалалтын захиргааны ажилтан болон байгаль хамгаалагч нь байгаль орчны улсын байцаагчийн эрхтэй байна.

56.3 Байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нь Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай болон байгаль орчны бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

56.4 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

57 дүгээр зүйл зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

57.1 Байгаль орчны хяналтын улсын байцаагч, шүүгч тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээд, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан зөрчлийн шийтгэл ногдуулна:

57.1.1 энэ хуулийн 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21 22, 23, 24-т заасан дэглэм, горимыг зөрчсөн иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, үйл ажиллагааг зогсоон, байгалийн төлөв байдал, ургамал, амьтанд хохирол учруулсан бол гэм буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ;

57.1.2 энэ хуульд заасан тусгай хамгаалалттай газар нутагт хориглох үйл ажиллагааг зөрчсөн иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, үйл ажиллагааг зогсоон, байгалийн төлөв байдал, ургамал, амьтанд хохирол учруулсан бол гэм буруутай этгээдээр хохирлыг гурав дахин нэмэгдүүлж нөхөн төлүүлнэ;

57.1.3 энэ хуулийн 38.1, 49.2, 51.3-51.6-д заасан үүргээ биелүүлээгүй иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

57.1.4 энэ хуулийн 30, 33.1.15, 53, 54-т заасан байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд төрөөс төсөвлөн олгосон болон сангийн хөрөнгө, ажил үйлчилгээний хураамж, байгаль орчин, байгалийн нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөр, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, захиргааны шийтгэлийн орлого, хандив, тусламжийг өөр зориулалтаар ашигласан албан тушаалтныг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ;

57.1.5 энэ хуулийн 33-37-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлээгүй албан тушаалтныг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;

57.1.6 тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн тэмдэг, тэмдэглэгээ, бусад эд хөрөнгийг эвдсэн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг арилгуулна;

57.1.7 тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааг зөрчсөн, хэрэгжүүлээгүй иргэн, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, хуулийн этгээд, албан тушаалтныг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.

58 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

58.1 Энэхүү хуулийг 20... оны сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.